



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26-74-68, <http://www.mof.gov.mn>

2017.05.05 № 4-1/2643
танай _____-ны № _____-т

Төсвийн хуваарь хүргүүлэх тухай

“Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай”, “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2017 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2018-2019 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулиуд болон дагалдах хууль, Улсын Их Хурлын тогтоолууд Улсын Их Хурлын 2017 оны 04 дүгээр сарын 14-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэгдэн батлагдсантай холбогдуулан төсвийн тухай хуулийн 11.1.13-т заасны дагуу “Төсвийн хуваарь батлах тухай” Сангийн сайдын 136 тоот тушаал батлагдлаа.

Төсвийн тухай хуулийн дагуу Монгол Улсын 2017 оны төсвийн тодотголын сар, улирлын хуваарь батлагдсантай холбогдуулан төсвийн ерөнхийлөн захирагч нарын төвлөрүүлэх орлого, зарлагын сар, улирлын хуваарийг хүргүүлж байна.

Төсвийн санхүүжилтийг батлагдсан сар, улирлын хуваарийн дагуу санхүүжүүлж, төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, нэгдсэн тайланг хуульд заасан хугацаанд гарган тайлагнаж ажиллана уу.

Хавсралт №1: Монгол Улсын 2017 оны төсвийн сар, улирлын хуваарийн тушаалын хуулбар;

Хавсралт №2: Төсвийн ерөнхийлөн захирагчийн Монгол Улсын 2017 оны төсвийн орлогын сар, улирлын хуваарь;

Хавсралт №3: Төсвийн ерөнхийлөн захирагчийн Монгол Улсын 2017 оны төсвийн зарлага, санхүүжилтийн сар, улирлын хуваарь;

Хавсралт №4: Улсын төсвийн хөрөнгөөр 2017 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга, байгууламжийн сар, улирлын хуваарь;

Хавсралт №5: Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлэх “Барих-Шилжүүлэх” концессын төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн сар, улирлын хуваарь;

Хавсралт №6: Эрчим хүч, дулааны алдагдлын 2017 оны татаасын хуваарь;

Хавсралт №7: Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн сар, улирлын хуваарь;

Хавсралт №8: Монгол Улсын 2017 оны төсвийн тодотголын онцлог, анхаарах зүйлс;



Б.ЧОЙЖИЛСҮРЭН